



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

Г Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих талаар Т  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг, 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1</sup>.1 дэх хэсэг, "Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2014 оны 18 дугаар тогтоол, "Жагсаалт батлах тухай" 2015 оны 336 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

- 1.1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжиж, стандарт, чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах болон ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэх;
- 1.2. Байгууллагын өөрийн хэрэгцээнд дотоодын үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүнийг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авч хэвшүүлэх;
- 1.3. Тендерийн үнэлгээг хийхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан давуу эрхийг тооцож ажиллах;

2. Тухайн жилийн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланд дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих ажилласан талаар тусгаж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор яаманд ирүүлж байхыг Төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалыг Төсвийн захирагч нарт хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Нандинжаргал/-д даалгасугай.

САЙД

Д.СУМЬЯАБАЗАР



08 0654